

БОГИНО ХУГАЦААНЫ НИЙТЛЭГ (С-3-1)

ОЛГОХ ХҮРЭЭ :

БНСУ-д зохиогдож буй нөхөрсөг тэмцээн уралдаан, үйл ажиллагаа, хурал цуглаан зэрэгт оролцох мөн улсын болон хувийн хэвшлийн байгууллагаас зохиогдож буй техник, технологийн дадлага сургалтад хамрагдахын тулд богино хугацаагаар зорчих иргэн

Зорчих зорилго болон холбогдох бичиг баримт С-3-19 (богино хугацааны урилгатай) С-3-4 (богино хугацааны хөдөлмөр эрхлэх) ангиллуудын хувьд өөр байна.

Дээрх богино хугацааны урилга ангилалд хамаарагдах хэдий ч байр, хоолны зардлаас илүү хэмжээний урамшуулал авах тохиолдолд, Богино хугацааны хөдөлмөр эрхлэх (С-4-5) ангиллын виз мэдүүлнэ

Урилгатай байх нь визний зөвшөөрөл шууд олгогдоно гэсэн үг биш гэдгийг анхаарна уу.

БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг)
2. Гадаад паспорт эх хувиар, мөн хуулбар 1 хувь
3. Гэрлэлтийн лавлагаа (лавлагааны хүчинтэй хугацаа 45 хоног)
 - Насанд хүрээгүй хүүхэд(19-өөс доош насныхан) бол төрсний бүртгэлийн лавлагаа (Хэрэв эцэг эхийн төрсөн он, сар, өдөр бичигдээгүй бол эцэг эхийн биеийн байцаалтын хуулбарыг хавсаргана)
4. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
 - Аж ахуйн нэгжийн захирал: Байгууллагын татварын тодорхойлолт, аж ахуйн нэгжийн гэрчилгээ
 - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, нийгмийн даатгал төлсөн лавлагаа, ажлын газрын тодорхойлолт
 - Бусад нөхцөл: Виз мэдүүлэгчийн нэр дээрх сүүлийн 6 сарын дансны хуулга (Хамтран эзэмшигчгүй байх)

***(19-өөс доош 55-аас дээш насны иргэд гэр бүлийн хамт виз мэдүүлэх тохиолдолд санхүүгийн чадвар нотлох бичиг баримтаас чөлөөлөгдөнө)**
5. Урилгатай холбоотой бичиг баримт (*уригч байгууллагын аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбараас бусад холбогдох бүх бичиг баримтуудыг эх хувиар авсан байх шаардлагатай. Нотариатаар батлуулах шаардлагагүй.)

Солонгос талын уригч байгууллага:

 - Урилга (Уригдагчдын нэрсийн жагсаалт, урьж буй зорилго, зардал хариуцагч тал, урьж буй хугацаа зэргийг заавал бичнэ.)

*Уригч байгууллагад тодорхой урилгын форматгүй тохиолдолд урилгын загварыг ЭСЯ-ны вэбсайтаас харж болно.

 - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 - Хамтын ажиллагааны тухай албан бичиг (урилгад тусгасан байж болно.)
 - Үйл ажиллагаа (сургалт, дадлага, семинар, албан уулзалт зэрэг)-ны хөтөлбөр, танилцуулга, зорчих зорилгыг нотолсон бичиг баримт

Монгол талын уригч байгууллага:

 - (Багаар уригдах тохиолдолд) Байгууллагын албан бичиг
 - (Хувь хүнийг урих тохиолдолд) Хүсэлт бичиг

<БНСУ-ын Спортын хорооны урилга>
БНСУ-ын Спортын хорооны харьяа байгууллагын урилга, мөн холбогдох яамны сайдын албан хүсэлт байх тохиолдолд санхүүгийн чадвар нотлох бичиг баримтаас чөлөөлөгдөх боломжтой
 * БНСУ-ын Спортын хорооны харьяа байгууллагын бүртгэлээс шалгах шаардлагатай (<https://www.sports.or.kr/>)
6. Итгэмжлэх бичиг (Насанд хүрээгүй виз мэдүүлэгч эцэг эхийн хамт биш мэдүүлэх болон хилээр нэвтрэхэд зайлшгүй шаардлагатай)